

ХУРЛЫГ НЭЭЖ ШУА-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Б.ЭНХТҮВШИНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нараа

Эрхэм хүндэт зочид оо

Та бүхэнд Монгол, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосоны 90 жилийн ойн баярын мэнд хүргэе.

Энэ жил Монголд түүхэн олон тэмдэглэлт ой тохиож байна. Тэртээ 1921 онд Засгийн газрын шийдвэрээр Судар бичгийн хүрээлэн байгуулагдсан нь өнөөгийн Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн суурь байлаа. 1920-иод оны тэр жилүүдэд Судар бичгийн хүрээлэнд Оросын нэрт аялагч академич П.К.Козлов тэргүүтэй эрдэмтэд зочилж, хоёр улсын шинжлэх ухааны талаар хамтран ажиллах тухай ярилцаж, улмаар гэрээ байгуулсан нь эдүгээ түүх болон үлджээ. Тэр цагаас хойш хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллагын салбарт хамтын ажиллагаа тасралтгүй өрнөсөөр эдүгээ хүрчээ.

Өнөөдөр Монгол, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосоны 90 жилийн ойг Монгол Улсын Гадаад харилцааны яам, Шинжлэх Ухааны Академи хамтран тэмдэглэж байна. Энэ бол эл ойн хүрээнд зохион байгуулж байгаа хоёр дахь эрдэм шинжилгээний хурал юм.

Дөнгөж саяхан Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн гадаад гишүүнээр сонгогдсон ОХУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, Сибирийн салбарын дарга, эрдэмтэн Асеев болон Буриадын Эрдэм шинжилгээний төвийн дарга, эрдэмтэн Базаров Б.В. нарт өргөмжлөлийг бид гардуулан өгсөн билээ.

Ийнхүү жилээс жилд Монгол, Оросын харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Хуралд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, ОХУ-аас Монгол Улсад суугаа Бүрэн эрхт элчин сайд Самойленко Виктор Васильевич болон эрхэм зочлод талархал илэрхийлж байна.

Манай хуралд ОХУ-ын Эрхүү хотын Улсын их сургуулийн профессор Кузьмин Юрий Васильевич, профессор Лиштованный Евгений Иванович, Читийн Ар Байгалийн их сургуулийн проректор Кузнецов В.В., профессор Васильев Г.Г. нарын зочид оролцож илтгэл тавьж байгааг дуулгахад таатай байна.

Манай хуралд Гадаад харилцааны яам, ШУА, Батлах хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Стратеги судлалын хүрээлэн, МУИС болон бусад их дээд сургуулийн эрдэмтэн багш нар оролцож байна.

Ингээд Монгол, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосоны 90 жилийн ойд зориулан Монгол Улсын Гадаад харилцааны Яам, Шинжлэх Ухааны Академи, Олон улс судлалын хүрээлэнгээс хамтран зохион байгуулж байгаа “Монгол Улс, ОХУ-ын харилцаа: Түүх ба орчин үе” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа